



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот


Хан-Уул дүүрэгт 2025-2028 онд
хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүрэгт 2025-2028 онд хэрэгжүүлэх “Бүтээгч Хан-Уулчууд” дэд хөтөлбөрийг нэгдүгээр, “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийг хоёрдугаар, “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийг гуравдугаар, “Эрүүл мэнд, боловсролыг дэмжих” дэд хөтөлбөрийг дөрөвдүгээр, “Соёл, спортыг дэмжих” дэд хөтөлбөрийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дэд хөтөлбөрүүд батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тайлагнан ажиллахыг дүүргийн Засаг дарга (Б.Цэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ